



БАТЛАВ: ЗАХИРАЛ *Ч.БАЗАР* Ч.БАЗАР

**“ЗУРШИЛ БҮТЭЭХ” ФЭЙСБҮҮК БҮЛГИЙН ГИШҮҮДИЙН ДУНД ЗОХИОН
БАЙГУУЛАХ “ХӨЛ ХОРИОНЫ ҮЕД ЭЕРЭГ ЗУРШИЛ БҮТЭЭХ НЬ” СЭДЭВТ
ЭСЭЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

1.ЗОРИЛГО

Дэлхийд хурдацтай тархаж буй Ковид-19 вирусийн халдвар манай улсын дотоодод илэрч, улмаар тархалтыг зогсоох зорилгоор бүх нийтийн бэлэн байдал зарлан, хөл хорио тогтоосон цаг хугацаанд бид амьдарч байна. Хөл хорионы үеэр хүмүүсийн амьдралын хэв маяг алдагдсанаар сэтгэл санаа, бие махбодын идэвхигүй байдал үүсч байна. Амьдралын идэвхигүй байдал нь сэтгэл зүйн хямрал, стресс үүсгэж, биеийн дархлааг сулруулж үүнээс үүдэн сэтгэцийн өөрчлөлт, өвчлөл үүсгэх эрсдэлтэй. Иймд Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль хөл хорионы үед өөртөө эерэг зуршил бүтээж, амьдралын идэвхитэй байгаагаа бусадтай хуваалцаж, олон нийтийг хөл хорионы үед өөртөө эерэг зуршил бүтээхийг дэмжих зорилгоор “Зуршил бүтээх групп”-ийн гишүүдийн дунд эсээ бичлэгийн уралдаан зарлаж байна.

2. УРАЛДААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ:

“Зуршил бүтээх групп” фэйсбүүк группийн гишүүд.

3. УРАЛДААНЫ ХУГАЦАА

2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 12 сарын 20-ны өдөр хүртэл

4. ЭСЭЭ БИЧЛЭГТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

- ✓ Өөртөө болон гэр бүлдээ бий болгосон эерэг зуршилынхаа талаар бичихдээ амьдралынхаа хэмнэлд гарсан өөрчлөлт, ямар үр дүнд хүрч байгаагаа тодорхой тусган бичих
- ✓ Уншигч таны эерэг зуршлаас өөрийн амьдралд хэрэгжүүлэх санаа төрөхөөр уриалсан, өдөөсөн, дэмжсэн хандлагатай байх
- ✓ Хэл найруулга, бичлэгийн ур чадвар сайн байх



- ✓ Бүтээлчээр хандах
- ✓ Тогтоосон хугацаанд ирүүлсэн байх
- ✓ Эсээний үсгийн фонт Times new roman 12 pt, Мөр хоорондын зай 1.5 байх

4. ШАГНАЛЫН САН

ТЭРГҮҮН БАЙР- 1 ЭСЭЭ, (Өргөмжлөл, 100,000 төгрөг, дурсгалын зүйл)

ДЭД БАЙР БАЙР- 1 ЭСЭЭ, (Өргөмжлөл 75,000 төгрөг, дурсгалын зүйл)

ТУСГАЙ БАЙР- 1 ЭСЭЭ, (Өргөмжлөл 50,000 төгрөг, дурсгалын зүйл)

Мөн эсээний уралдаанд бүтээлээ ирүүлсэн бүх оролцогчдод Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн эчнээ хөтөлбөрт суралцах 5%-ийн хөнгөлөлтийн эрхийн бичиг гардуулна.

5. ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ

Эсээг 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2020 оны 12 сарын 20-ны хооронд Munkhjin8890@gmail.com

эсвэл <https://www.facebook.com/profile.php?id=100046165840826> фэйсбүүк хаягаар хүлээн авна.

Оролцогч бүтээлээ явуулахдаа өөрийн овог нэр, хаяг, утасны дугаар, фэйсбүүк хаягаа тодорхой бичнэ.

Нэмэлт мэдээллийг 90872222 утсанд холбогдож авна уу.

2020.12.10